




# Өөрчлөлт миний гарт

ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙМЭЭС УРЬДЧИЛАН  
СЭРГИЙЛЭХ МЭДЛЭГ, ХАНДЛАГА, ЧАДВАР ОЛГОХ  
ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

СУРАГЧДАД ЗОРИУЛСАН  
ГАРЬН АВЛАГА - III



ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЭС УРЬДЧИЛАН  
СЭРГИЙЛЭХ МЭДЛЭГ, ХАНДЛАГА, ЧАДВАР ОЛГОХ  
ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

# Өөрчлөлт миний гарт

СУРАГЧДАД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА – III

**2016 ОН**  
УЛААНБААТАР ХОТ



Монголын Эмэгтэйчүүдийн Сан (МОНЭС) нь эмэгтэйчүүдийн хөгжил дэвшлийн төлөө нөөц, баялаг, мэдлэг, арга ухаан хуримтлуулж, санхүүгийн болон мэдлэг арга зүйн дэмжлэг үзүүлдэг юм.

Энэхүү гарын авлагыг НҮБ-ын Итгэлцлийн сангийн санхүүжилт, МОНЭС-гийн арга зүйн дэмжлэгтэйгээр “ДОРНОД АЙМАГ, БАГАНУУР ДҮҮРГИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН АХЛАХ АНГИЙН СУРАГЧДАД ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД ТӨРИЙН ДЭМЖЛЭГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ” төслийн хүрээнд боловсруулав.

**Боловсруулсан:** Ч. Ундрах, MHRP  
Б. Ариунсанаа, MPH, MSW

**Зөвлөсөн:** Ч. Алтанцэцэг, Багануур дүүргийн Боловсрол цогцолбор сургуулийн Сургалтын менежер  
З. Болормаа, Багануур дүүргийн Гүн Галуутай цогцолбор сургуулийн Сургалтын менежер  
Б.Уранжаргал, Дорнод аймгийн Хэрлэн сумын 5-р сургуулийн Сургалтын менежер

Энэхүү гарын авлагыг Монголын эмэгтэйчүүдийн сангийн зөвшөөрөлгүйгээр бүхлээр нь, эсвэл хэсэгчлэн хэвлэн олшруулахыг хориглоно. Аливаа хэлбэрээр ашиглах тохиолдолд эх сурвалж буюу МОНЭС-ийн нэрийг заавал дурдана.

### **Монголын Эмэгтэйчүүдийн Сан (МОНЭС)**

**Хаяг:** Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо  
Бага тойруу, 48-р байр, 305 тоот

**Утас:** 77119991

**Цахим шуудан:** [mones@mongol.net](mailto:mones@mongol.net) | [info@mones.org.mn](mailto:info@mones.org.mn)

**Нүүр хуудас:** [Mongolian Women's Fund](http://MongolianWomen'sFund)

**Веб хуудас:** [www.Mongolianwomensfund](http://www.Mongolianwomensfund)

**Фэйсбүүк хуудас:** [Mongolian Women's Fund](http://MongolianWomen'sFund)



## ЗОХИОГЧИЙН ҮГ


Хүчирхийлэлгүй нийгмийг бүтээхэд хувь нэмрээ оруулж буй өөрчлөлтийн эзэн болсон хүүхдүүд та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе!

“ӨӨРЧЛӨЛТ МИНИЙ ГАРТ” хэмээх жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэдлэг, хандлага, чадвар олгох 8 модуль бүхий хичээлийн 16 удаагийн хичээлийг үзэж судлаад байгаа билээ.

Өнгөрсөн хугацаанд бид жендэрт суурилсан хүчирхийлэлтэй холбоотой чухал ойлголтуудын талаарх мэдлэгийн хүрээгээ тэлж, хандлагаа өөрчлөхийг эрэлхийлж, өөртөө болон найз нөхөддөө дадал төлөвшүүлж эхэлцгээсэн билээ. Харин өнөөдрөөс эхлэн бид хүчирхийлэлгүй нийгмийг бий болгохын тулд илүү санаачлагатай байж, өөрийн биеэр оролцох болно.

Жендэрт суурилсан хүчирхийлэлгүй нийгэм чиний, та бүгдийн гарт байгаа шүү!





# ГАРЧИГ

<b>Модуль 1:</b>	<b>Хүний эрх</b> <i>Хүний эрхийг хэн, хэрхэн хамгаалах вэ?</i>	<b>08</b>
<b>Модуль 2:</b>	<b>Жендэр</b> <i>Би зориг гаргаж чадах уу?</i>	<b>14</b>
<b>Модуль 3:</b>	<b>Хүчирхийлэл</b> <i>Хүчирхийллээс сэргийлэхэд бид хэрхэн оролцох вэ?</i>	<b>24</b>
<b>Модуль 4:</b>	<b>Жендэрт Суурилсан Хүчирхийлэл</b> <i>Бид хүчирхийлэлгүй сургуулийг Бий болгож чадах уу?</i>	<b>32</b>
<b>Модуль 5:</b>	<b>Жендэрт суурилсан хүчирхийллийн үр дагавар</b> <i>Бэлгийн эрүүл мэндэд ямар үр дагавар үүсгэдэг вэ?</i>	<b>36</b>
<b>Модуль 6:</b>	<b>Жендэрт суурилсан хүчирхийлэлд хариу арга хэмжээ авах</b> <i>Жендэрт суурилсан хүчирхийллийн тохиолдлыг хэрхэн мэдээлэх вэ?</i>	<b>44</b>
<b>Модуль 7:</b>	<b>Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, Өөрийгөө хамгаалах</b> <i>Би өөрийгөө болон найзыгаа хамгаалж чадах уу?</i>	<b>50</b>
<b>Модуль 8:</b>	<b>Жендэрт суурилсан хүчирхийллийг таслан зогсоох</b> <i>Жендэрт суурилсан хүчирхийлэлгүй орчныг хэрхэн бий болгох вэ?</i>	<b>56</b>

**Хичээлийн сэдэв:**

ХҮНИЙ ЭРХИЙГ ХЭН,  
ХЭРХЭН ХАМГААЛАХ ВЭ?



## ХИЧЭЭЛИЙН ЗОРИЛГО

“Бид хүний эрхийг хамгаалж чадах уу?,” “Хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх боломжтой юу?” гэх мэт асуултын харилуцыг олохын тулд хичээлийнхээ зорилготой танилцана уу!

*Энэхүү хичээлийн гол зорилго нь хүний үндсэн эрхүүд болон түүний хамгаалалтын талаарх суурь мэдлэгт тулгуурлан хүний эрхийн асуудалд олон талаас хандах, өөрийн үзэл бодлыг төлөвшүүлэх явдал юм.*

### Уг хичээлийг судалснаар,

- Хүний үндсэн эрхүүдийн талаарх ойлголт мэдлэгээ бататгана.
- Хүний эрхийн зөрчлүүдийг таньж мэддэг болно.
- Хүний эрхийг зөрчихөөс сэргийлэх, хүний эрх зөрчигдөхөөс хамгаалах ухамсарт суралцана.
- Хүний эрхийн тухай мэдээлэлд дүн шинжилгээ хийх чадварт суралцана.

Мөн түүнчлэн өмнөх жилүүдэд үзсэн хүний эрхийн тухай үндсэн ойлголт, мэдлэгээ гүнзгийрүүлж бататгахаас гадна энэ удаагийн хичээлээр хүний эрхийг олон талаас нь харж, өөрсдийн үзэл бодлыг төлөвшүүлэхэд чиглэнэ гэдгийг анхаарна уу!

## ХИЧЭЭЛИЙН ДАРААЛАЛ

Дор өгөгдсөн дасгалуудыг дэс дараалалтайгаар ажиллаж хүний эрх зөрчигдөхөөс сэргийлэх боломжтой эсэхийг олж мэдээрэй.

1. Сэдэлжүүлэлт
2. Видео лекц ба хэлэлцүүлэг



### Дасгал 1

## СЭДЭЛЖҮҮЛЭЛТ

Бид өмнө нь “хүний эрх”-ийн тухай 2 удаагийн хичээл үзэж судалсан билээ. Эхний удаад хүн, эрх, хүний үндсэн эрхийн талаарх ойлголт мэдлэгийг хөгжөөнт тоглоомын тусламжтайгаар олж мэдсэн бол дараагийн удаад “Хүний эрх гэж юу вэ?” хэмээх богино хэмжээний видео киноноос хүний эрх хаанаас, хэнээс эхлэлтэй болох, хүний эрхийг хэн хамгаалдаг болохыг мэддэг болсон. Иймд ойролцоо сууж буй найзуудтайгаа чөлөөт ярилцлага хийж өмнөх жилүүдэд үзсэн “хүний эрх”-ийн хичээлээс олж авсан чухал ойлголтуудыг гаргаж ирнэ үү!

Хичээл тус бүрийн хүрээнд дор хаяж 5 чухал мэдээллийг доорх хүснэгтэд харгалзуулан жагсааж бичээрэй!

<p><b>“Хүн гэж хэн бэ? Эрх гэж юу вэ?” хичээл</b></p>	
<p><b>“Хүний эрх гэж юу вэ?” хичээл</b></p>	



**Дасгал 2**

**ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

Хүний эрхийн активист Б. Болорсайханы “Хүний эрх гэж юу вэ?” лекцийн мөрөөр доорх асуултуудын хүрээнд ангийнхантайгаа хэлэлцүүлэг өрнүүлнэ. Мөн түүнчлэн хэлэлцүүлгээс олж мэдсэн чухал мэдээллүүдийг доорх зайд тэмдэглээрэй!

**ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН АСУУЛТУУД**

**Хүн гэж хэн бэ? Хүнийг тодорхойлоход юуг анхаарч авч үзэх ёстой вэ?**

---

---

---

---

---

---

**Хүнийг тодорхойлоход дээрх асуудлуудыг яагаад авч үзэх ёстой вэ?**

---

---

---

---

---

---

**Тэгэхээр хүний эрх гэж юу вэ?**

---

---

---

---

---

---

**Хүний эрх ямар шинжтэй вэ?**

---

---

---

---

---

---



## ХИЧЭЭЛИЙН ДҮГНЭЛТ

“Хүний эрх гэж юу вэ?” сэдэвт хичээлийг үзсэнээр дараах дүгнэлтийг өөртөө бий болгож, хүний эрхийн талаар ойлголт, мэдлэгээ гүнзгийрүүлээрэй!

- “Хүний эрхийг хэн, хэрхэн хамгаалах вэ?” хичээлийн үр дүнд дараах хэд хэдэн гол дүгнэлтэд хүрсэн гэдэгт эргэлзэхгүй байна.
- Хүн бол биологийн, нийгмийн шинжтэйгээс гадна өөрийн гэсэн оюун ухаан зүрх сэтгэлтэй учраас хүний үйлдэл бүрийн дийлэнх нь ухамсарлагдсан байдаг.
- Хүн нийгмийн амьдралд оролцож байх цаг мөч бүрт шийдвэр гаргаж, сонголт хийж байдаг. Энэ нь тухайн хүний сонголтын эрх чөлөөтэй салшгүй холбоотой. Ямар сонголт хийснээс шалтгаалж бусдын эрхэнд халдсан, бусдын эрхийг үл хүндэлсэн тухай асуудал үүсдэг.
- Хүний эрх нь түгээмэл буюу бүгдэд хамаатай, туйлын буюу гарцаагүй, салшгүй буюу сонголтоос үл хамаарсан шинжтэй. Хүн эрхээ сонгож авдаггүйтэй адил эргүүлж өгнө гэсэн ойлголт байхгүй.
- Бид хүний эрхийн мэдлэгээ тэлж, боловсролоо гүнзгийрүүлснээр хүний эрхийг хамгаалж, түүний аливаа зөрчлөөс сэргийлэх бүрэн боломжтой.





**Хичээлийн сэдэв:**

БИ ЗОРИГ ГАРГАЖ  
ЧАДАХ УУ?

## ХИЧЭЭЛИЙН ЗОРИЛГО

Хүүхдүүд ээ! Энэ удаагийн хичээлийнхээ зорилготой танилцана уу. Мөн түүнчлэн уг хичээлийг судалснаар ямар үр дүн гарахыг дор дурьдсан байгааг анхааралтай уншина уу!

*“Би зориг гаргаж чадах уу?” сэдэвт хичээлийн гол зорилго нь нийгмээс охид, хөвгүүдэд оноосон жендэрийн хэвшмэл дүрийн талаарх ойлголт мэдлэгээ гүнзгийрүүлж, жендэрийн зарим уламжлалт хандлагыг өөрчлөх алхам хийх явдал юм.*

Уг хичээлийг судалснаар

- Жендэрийн хэвшмэл дүрийн талаарх ойлголтоо бататгана.
- Хүний биологийн хүйстэй холбоотой нийгмээс оногдуулсан үүрэг хариуцлага, шаардлага зэрэгт шүүмжлэлт байр сууринаас ханддаг болно.
- Жендэртэй холбоотой хувийн үзэл бодол өөрчлөгдөнө.

## ХИЧЭЭЛИЙН ДАРААЛАЛ

Дараах дасгалуудыг өгөгдсөн зааварчилгааны дагуу найзуудтайгаа болон бие даан хийх замаар хүний үндсэн эрхийн талаарх суурь ойлголттой болцгооё.


1. Би ямар алхам хийх вэ?
2. Чөлөөт ярилцлага
3. Миний зоригтой алхам /гэрийн даалгавар/

### Дасгал 1

## БИ ЯМАР АЛХАМ ХИЙХ ВЭ?

Хоёр хоёроороо багт хуваагдана. Ингэхдээ охид нь охидтой, хөвгүүд нь хөвгүүдтэй баг болох ёстой бөгөөд багууд дор өгөгдсөн нөхцөлүүдийн талаар хоорондоо ярилцаж, ямар алхам хийх талаараа шийдэлд хүрнэ. Ямар шийдэлд хүрч болох тухайгаа өгөгдөл бүрийн доорх зайнд тэмдэглэж үлдээгээрэй!

### ХӨВГҮҮДИЙН БАГ ДООРХ НӨХЦӨЛҮҮДИЙН ТАЛААР ЯРИЛЦАЖ, ГАРГАСАН ШИЙДВЭРЭЭ ТОВЧ ТЭМДЭГЛЭНЭ ҮҮ!

 Дүү охин чинь маргааш химийн хичээлийн шалгалттай гэдгийг чи сайн мэдэж байгаа. Анги дэвших шалгалт учраас түүний хувьд маш чухал. Гэсэн хэдий ч гэрт чинь орой зочин ирнэ гэсэн учраас дүү чинь гэрээ цэвэрлээд маш завгүй байгаа. Харин найзууд чинь гадаа ирчихсэн хамт сагс тоглоё гэж чамайг дуудсан.


---

---

---

---

---

 Чамд нэг удаа маш хэцүү зүйл тохиолдсон учраас чи ангидаа байхдаа уйлчихсан. Тэр явдлаас хойш найзууд чинь, ангийнхан чинь чамайг “уйланхай”, “охин шиг” гэж шоолдог болсон.


---

---

---

---

---

 Чи 18 настай. Гэхдээ одоог хүртэл бэлгийн хавьталд ороогүй байгаа. Учир нь хайртай хүнтэйгээ л үүнийг хийх ёстой гэж чи дотроо боддог. Гэвч найз хөвгүүд чинь чамайг “эр хүн байж доожоогүй” гэж байнга элдвээр гоочилдог.

---

---

---

---

---





Сургууль дээр их цэвэрлэгээ хийх шаардлагатай болсон. Ангийн багш чинь эр хүнээр гэр орны ажил хийлгэх нь зохимжгүй гэж үздэг хүн тул хөвгүүдээр хог шүүрдүүлж, шал угаалгахгүй, тэр ч бүү хэл хог асгуулахгүй гэдэг. Гэтэл чиний хайртай охин цэвэрлэгээ хийгээд маш их ядарсан байна.



Чи бусад хөвгүүдтэй харьцуулбал бага зэрэг нарийхан хоолойтой, бас туранхай. Сургуулийнхан чинь чамайг “охин” гэж байнга дооглодог.

**Охидын баг доорх нөхцөлүүдийн талаар ярилцаж, гаргасан шийдвэрээ товч тэмдэглэнэ үү!**



Чи физик, химийн хичээлдээ маш их дуртай. Ирээдүйдээ “уул уурхайн инженер” болно гэж боддог ч ээж, аав чинь чамайг заавал “эмч” болгоно гэдэг. Яагаад гэвэл эмэгтэй хүн уул уурхайн ажил хийж чадахгүй, зөвхөн эрэгтэйчүүд л ийм ажил хийдэг гэж хэлдэг.




Танай ангийн охин спортоор хичээллэдэг. Бэлтгэл, сургуулилт гээд чөлөөт цаг муутай учраас ангийнхаа охидтой тийм ч дотно биш. Түүнийг танай ангийнхан бүгд л “эрэгтэй хүүхэд” шиг, “хэзээ ч найз хөвгүүнтэй болохгүй байх” гэж ярьцгаадаг.

---

---

---

---


 *Чи 1 ахтай, бас 1 эрэгтэй дүүтэй. Та нар бүгд л гэрийн ажлаа хувааж хийдэг. Нэг өдөр ах чинь шалаа угааж байтал ээжийн чинь найз эмэгтэй танайд ирээд чамайг зэмлэсэн. “Охин хүүхэд байж ганц ахаараа шал угаалгаад байхдаа яахав дээ” гэсэн.*

---

---

---

---


 *Чиний эгч 30 гаруй насны ажил хэрэгч, ганч бие эмэгтэй. Удирдаж ажиллуулдаг компани нь маш амжилттай ажилладаг. Гэсэн хэдий ч танай хамаатнууд эгчийг чинь хүнтэй сууж, хүүхэд гаргах хэрэгтэй гэж байнга ятгадаг.*

---

---

---

---

 *Нэг орой найз хөвгүүнтэйгээ гудамжаар зугаалж явтал 2 залуу ирээд чамайг хоргоосон. Найз хөвгүүн чинь чамайг хамгаалахыг хичээсэн боловч чадалгүй тэдгээр залууст зодуулжээ. Энэ явдлаас хойш танай найз охидууд чамайг “найз охиноо хамгаалж чаддаггүй доожоогүй хөвгүүнээс сал” гэж байнга хэлэх болсон.*

---

---

---

---



**Дасгал 2****ЧӨЛӨӨТ ЯРИЛЦЛАГА**

Охид, хөвгүүдийн баг тус бүр өгөгдсөн нөхцөлүүдийн талаар нэг бүрчлэн ярилцаж, өөрсдийн гаргасан шийдлийг бусаддаа танилцуулаарай! Багууд бие биенээсээ асуулт асуух эсвэл гаргасан шийдвэрийнх нь талаар санал бодлоо чөлөөтэй хуваалцах боломжтой. Дараах асуултуудын дагуу ярилцлагаа өрнүүлээрэй!

**ЧИГЛҮҮЛЭХ АСУУЛТУУД**

- Бодит амьдрал дээр өгөгдсөн нөхцөлтэй ижил төстэй үйл явдал хэр их тохиолддог вэ?
- Тэдгээр тохиолдлуудад дийлэнхдээ ямар шийдвэр гаргадаг вэ?
- Өгөгдсөн нөхцөлтэй холбоотойгоор ямар нэг шийдвэр гаргах ямар байсан бэ?
- Гаргасан шийдвэртээ хэр зэрэг сэтгэл хангалуун байна вэ? Яагаад?
- Чиний гаргасан шийдвэр ямар ач холбогдолтой гэж бодож байна вэ?

Энэхүү дасгалыг ажилласнаар та нар өдрийг хэрхэн өнгөрүүлдэг болох, ямар ажилд хэдэн цаг зарцуулдаг болох, өдөрт хэдэн цаг унтаж, хэдэн цаг сэрүүн байдаг болохоо ч олж мэдлээ. Түүгээр ч барахгүй охид, хөвгүүд өөрийн биологийн хүйсээс шалтгаалан өдрийг хэрхэн ялгаатай, өөр өөрөөр өнгөрөөдөг болохыг олж харсан гэдэгт итгэлтэй байна. Нэн ялангуяа хичээлээс бусад цагийг охид, хөвгүүд хэрхэн ялгаатай өнгөрүүлж байгаа нь илүү сонирхолтой байсан биз ээ.







## ХИЧЭЭЛИЙН ДҮГНЭЛТ

“Би зориг гаргаж чадах уу?” сэдэвт хичээлийг үзэж судалснаар дараах дүгнэлтийг өөртөө бий болгосон гэдэгт эргэлзэхгүй байна.

- *Жендэр гэдэг үгийг сонсоход ойлгомжгүй, биднээс хол, эсвэл зөвхөн багш нар, мэргэжилтнүүдийн л ойлгодог зүйл мэт санагддаг. Гэвч жендэртэй холбоотой асуудлууд бидний өдөр тутмын амьдралд тохиолдож, бидэнтэй маш ойр, бидний хажууд, заримынх нь дотор ч оршиж байдаг. Тэр тусмаа бид амьдралынхаа алхам тутамд жендэртэй холбоотой сонголт хийж, шийдвэр гаргах шаардлагатай болдог.*
- *Өөрийн биологийн хүйсээс шалтгаалан бид хийхийг хүссэн зүйлээ хийж чадахгүй байх, хүслээ дагахгүй байх тохиолдол маш олон байдаг. Магадгүй бидний дийлэнх нь “эмэгтэй учраас...”, “эрэгтэй учраас...” гэдэг шалтгааны улмаас хүссэн сонголтоосоо, гаргасан шийдвэрээсээ няцахад хүрдэг. Иймд өөрийн үзлийг хуучинсаг, тэгш бус гэдгийг ухамсарлаж, бусдын хэвшмэл үзлийн шахалтаас ангижрах хэрэгтэй. Үүний тулд зоригтой алхам хийх хэрэгтэй болно.*
- *Жендэрийн дүрийн талаарх хэвшмэл ойлголт бидний эргэн тойронд, бидэнтэй маш ойрхон оршин байдаг. Гагцхүү бид тэрхүү жендэрийн хэвшмэл дүрийг өөрчлөх бүрэн боломжтой.*
- *Өөрчлөлт хийхийн тулд биднээс бага зэрэг зориг шаардагдана. Гэхдээ зориг гаргана гэдэг бол шинэ зүйлийг туршиж байгаатай ижил зүйл юм. Аливаа хэвшмэл зүйлийг өөрчлөх зориг биднээс л гарна.*





**Хичээлийн сэдэв:**

ХҮЧИРХИЙЛЛЭЭС

СЭРГИЙЛЭХЭД БИД

ХЭРХЭН ОРОЛЦОХ ВЭ?



## ХИЧЭЭЛИЙН ЗОРИЛГО

Хүүхдүүдээ “Хүчирхийллээс сэргийлэхэд бид хэрхэн оролцох вэ?” сэдэвт хичээл эхэлхэд бэлэн боллоо. Өмнөх жилүүдэд бид хүчирхийлэл гэж юу болох, түүний олон хэлбэрүүдтэй танилцсан бол энэ удаад бид хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, цаашлаад таслан зогсоохын тулд юу хийж чадах тухай үзэх болно.

Ингээд хичээлийнхээ зорилготой танилцаарай!

*Хүчирхийллийн хэлбэрүүдийн талаарх та бүхний мэдлэгийг гүнзгийрүүлж, ойлголтыг нэмэгдүүлэх замаар хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсооход хувь хүн бүрийн бодит оролцоо чухал болохыг ойлгуулахад хичээлийн гол зорилго оршино.*

*Ингэхийн тулд,*

- Сурагчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх замаар хүчирхийллийн эсрэг тэдний оролцоог нэмэгдүүлнэ.
- Хүчирхийллийг таслан зогсооход хүн бүрийн оролцоо чухал гэдгийг ойлгуулна.

## ХИЧЭЭЛИЙН ДАРААЛАЛ

Хичээл нь дараах бүтцийн дагуу явагдана.

- Сурталчилгааны видео үзэж хэлэлцүүлэг өрнүүлэх
- Зурагт хуудас бүтээх
- Мэдлэгээ бататгах



### Дасгал 1

## СУРТАЛЧИЛГААНЫ ВИДЕО ҮЗЭЖ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ӨРНҮҮЛЭХ

Багшийн зааварчилгааны дагуу 3 баг болон хуваагдан сууна. Та бүхэнд хүчирхийллийн өөр өөр төрлүүдийг илтгэсэн олон нийтийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилго бүхий богино хэмжээний сурталчилгааны видео үзүүлнэ. .

### Видео нь дараах сэдэвтэй байна.

- Хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх
- Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх
- Боловсрол, сургалтын орчин дахь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх

Сурталчилгааны видеонуудыг үзсэний эцэст доорх асуултуудын дагуу багийн гишүүдтэйгээ ярилцаж, түүнчлэн чөлөөт цагаараа бие даан хариулж бичээрэй!

### ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН АСУУЛТУУД

**Хүчирхийллийн мөн чанар юу вэ? Энэ нь бусад харилцааны асуудлаас юугаараа онцлог вэ?**

---



---



---



---



---



---

**Хүчирхийллийн хохирогч хэн байв? Хүчирхийлэгч нь хэн байв?**

---



---



---



---



---



---

**Хүчирхийлэл ямар орчин нөхцөлд болдог вэ?**

---



---

**Хүчирхийллийн төрлүүдэд ялгаа бий юу?**


---



---



---



---



---



---

**Дасгал 2****ЗУРАГТ ХУУДАС БҮТЭЭХ**

Та бүхэн 3-н багт хуваагдсан байгаа билээ. Түүнчлэн сурталчилгааны видео үзэж, баг тус бүр аль нэг төрлийн хүчирхийллийн талаар гүнзгийрүүлэн ярилцсан.

Харин одоо өөрийн багт оногдсон хүчирхийллийн төрөл болон түүнээс урьдчилан сэргийлэх, олон нийтийн, тэр тусмаа өсвөр насны хүүхдүүдийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх зорилго бүхий ЗУРАГТ ХУУДАС /плакат/ бүтээнэ.

Бүтээсэн зурагт хуудас чинь танай сургуулийн коридорт байрлана гэдгийг санаж өнгө үзэмж, агуулга, илэрхийлэл зэргийг сайтар тунгаан бодоорой!

**Плакатаа хийхээс өмнө түүний**

- Агуулга,
- Бусдад хүргэх гол санаа,
- Зорилго,
- Хүлээж буй үр дүнгийн талаар эхлээд баг дотроо сайтар ярилцаарай.

Жишээлбэл, танай багийн зурагт хуудас хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн тухай илэрхийлэхийг зорьж байгаа бол гол санаа нь ямар байх вэ, хүмүүс юуг ойлгох хэрэгтэй вэ, үүнийг хийж байгаа нь угтаа ямар зорилготой вэ, хэнд мессэж хүргэхийг хүсч байна вэ, эцэст нь үүнийг харсан хүн бүр өөртөө бусаддаа юуг уламжилж хэлээсэй гэж хүсч байна вэ гэсэн



**Дараах бүтцийг ашиглаж зурагт хуудсаа бүтээгээрэй!**

Агуулга	<ul style="list-style-type: none"> <li>● <i>Зурагт хуудсанд хүчирхийллийн ямар хэлбэрийг илүү онцолсон бэ?</i></li> <li>● <i>Эсвэл ерөнхийд нь хүчирхийллийн хор хөнөөлийн тухай өгүүлж байна уу?</i></li> </ul>
Гол санаа	<ul style="list-style-type: none"> <li>● <i>Хүмүүс анх хармагц ямар санааг ойлгох ёстой вэ?</i></li> <li>● <i>Хүчирхийлэл зөвхөн бие махбодид л хор хохиролтой юу?</i></li> <li>● <i>Сэтгэл санааны хүчирхийллийг яаж таних вэ? гэх мэт асуултуудын дагуу бодох хэрэгтэй</i></li> </ul>
Зорилго	<ul style="list-style-type: none"> <li>● <i>Хүмүүс өөрийн түвшинд мэдлэгтэй болох уу, найз нөхөд хайртай хэн нэгэндээ энэ талаар мэдээлэх үү?</i></li> </ul>
Хүлээлт	<ul style="list-style-type: none"> <li>● <i>Хүмүүс өөрийн түвшинд мэдлэгтэй болох уу, найз нөхөд хайртай хэн нэгэндээ энэ талаар мэдээлэх үү?</i></li> </ul>
Зорилго	<ul style="list-style-type: none"> <li>● <i>Хүмүүст мэдлэгийн өөрчлөлт, ахиц гарах уу, эсвэл зан үйл дадлыг өөрчлөх өөрчлөлт гарах уу?</i></li> <li>● <i>Анги хамт олон, сургуулийн орчинд хүчирхийллийн гаралтад нөлөөлөх үү?</i></li> <li>● <i>Чухам ямар өөрчлөлт гарах вэ?</i></li> </ul>
Бусад	<ul style="list-style-type: none"> <li>● <i>Өнгө үзэмж, өнгөний зохицол, үсгийн том жижиг, гол мессэж гэх мэт</i></li> </ul>

нарийн сэдвийн дагуу хийх ёстой юм шүү.

Багууд бүтээсэн зурсан зурагт хуудсаа ээлжлэн бие биедээ танилцуулж, гаргасан санаагаа тайлбарлана. Багийн гишүүд бие биенийхээ гүйцэтгэсэн ажлын талаар сонирхсон асуултаа чөлөөтэй асууж хариулт аваарай. Үүнд багш чиглүүлэх үүрэг гүйцэтгэнэ.

Дараах зайд зурагт хуудасныхаа ерөнхий санааг гаргаарай!

### **ЗУРАГТ ХУУДАС ЗУРАХ ТАЛБАЙ**

**Дасгал 3**

**МЭДЛЭГЭЭ БАТАТГАХ НЬ**

Доорх мэдлэг сорих тестэд хариулж, ЗӨВ гэж үзсэн хариултын өмнө асуултын дугаарыг тавиарай.

1.	Бие махбодийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд ямар шинж тэмдэгтэй байх вэ?		<i>Нүд хавдаж улайсан</i>
			<i>Нүд нь хөхөрч цохигдсон</i>
			<i>Биед илэрсэн шарх сорвийн талаарх тайлбар зөрчилтэй буюу үнэмшилгүй</i>
2.	Сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн хүүхэд ямар шинж тэмдэгтэй байх вэ?		<i>Гар нь улайж түлэгдсэн</i>
			<i>Тайван бус, айсан маягтай</i>
			<i>Бусдын ярианд оролцохгүй, сонсохгүй</i>
3.	Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд ямар шинж тэмдэгтэй байх вэ?		<i>Гунигтай, баяр баясгалангүй</i>
			<i>Хувцас нь ноорхой, энд тэндээ цоорхой, хир тортог ихтэй</i>
4.	Бие үл хайхрах хүчирхийлэлд өртсөн хүүхэд ямар шинж тэмдэгтэй байх вэ?		<i>Насандаа тохироогүй сексийн талаар ярих, үг хэллэг ашиглах</i>
			<i>Нэг төрлийн хувцсыг бүх улиралд өмсөх</i>
			<i>Байнга өлссөн шинжтэй байх</i>



## ХИЧЭЭЛИЙН ДҮГНЭЛТ

“Хүчирхийллээс сэргийлэхэд бид хэрхэн оролцох вэ?” сэдэвт өнөөдрийн хичээлээс дараах дүгнэлтийг хийж болохоор байна.

- *Хүчирхийллийн олон хэлбэр байдаг бөгөөд тэдгээр нь бидний сурч боловсрох орчин, гудамж талбайд өрнөж байдаг.*
- *Хүчирхийллийн шууд хохирогч хэн байв гэдгээс хамаарч хүүхдийн эсрэг, эмэгтэйчүүдийн эсрэг, ахмад настны эсрэг гэсэн төрлүүдэд мөн хувааж болдог. Хүнийг хүсээгүй байхад, хүсэл зоригийнх нь эсрэг үйлдэл учраас ЭСРЭГ гэсэн үгийг ашигладаг.*
- *Хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд хүн бүрийн, бүлэг хамт олон, нийгмийн оролцоо маш чухал. Энэ нь хувь хүн бүр, найз нөхдөөрөө ухамсарлахаас эхтэй.*
- *Хувь хүн бүр хүчирхийллийг эсэргүүцэж өөрийн дуу хоолой, үйлдлээрээ таслан зогсоохын төлөө оролцох боломжтой байдаг.*
- *Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсооход хүн бүрийн оролцоо чухал.*

**Хичээлийн сэдэв:**

БИД ХҮЧИРХИЙЛЭЛГҮЙ  
СУРГУУЛИЙГ БИЙ БОЛГОЖ  
ЧАДАХ УУ?





## ХИЧЭЭЛИЙН ЗОРИЛГО

Хүүхдүүдээ энэхүү хичээл бидний сургуульд хүчирхийлэлт харилцаа бий юу, хэрэв тийм бол түүнийг арилгахад бидний оролцоо юу байх вэ хэмээх сэдвийн хүрээнд явагдах болно. Ингээд хичээлийн зорилготой танилцана.

*Энэхүү хичээлийн зорилго нь боловсролын байгууллага, сургалтын орчин дахь жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоох, хүчирхийлэлгүй орчин бий болгоход сурагч та бүгдийн бодит, утга учиртай оролцоог бий болгох, хариуцлагатай, хүмүүнлэг иргэнийг төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулах явдал юм.*

*Ингэхийн тулд,*

- *ЖСХ-гүй анги, хамт олныг бий болгох замаар боловсрол, сургалтын орчныг сурагчдад ээлтэй, сурагчдын эрхийг дээдэлсэн шинжтэй болгоход нөлөө үзүүлэх,*
- *Хүчирхийлэлгүй анги, хамт олон болох нь бидний амьдрах, сурах орчинд хэр таатай нөлөө үзүүлэхийг ойлгоно.*

## ХИЧЭЭЛИЙН ДАРААЛАЛ

Дараах дарааллын дагуу ажиллана.

- Багаар ажиллах
- Танилцуулга хийх

## Дасгал 1

### БАГААР АЖИЛАХ

Хүүхдүүдээ багшийн зааварчилсны дагуу 2 хэсэг болон хуваагдан суугаарай. Багуудыг 2 өөр үзэл баримтлал бүхий нам гэж төсөөлөөд дараа намын даргаа хэнээр сонгохоо ярилцаж шийднэ. Нам тус бүр сургуулийн орчин дахь үе тэнгийнхний дундах хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоох зорилго бүхий хүний эрхэм чанарыг хүндэтгэсэн, хүчирхийлэлгүй анги байхын тулд 5-аас доошгүй заалттай “ХУУЛИЙН ТӨСӨЛ” боловсруулна. Уг хуулийн төсөлд хүчирхийлэл үйлдэгчдэд оногдуулах хариуцлагыг ч мөн тусгасан байх ёстойг санаарай.

Хуулийн төсөлд дараах зүйлсийг анхаараарай.

### АСУУЛТУУД

**Та бүхний санаж байгаагаар хамгийн сүүлд ямар зөрчилтэй асуудал ангид гарсан бэ?**

---

---

---

---

**Түүний учир шалтгаан нь юу байсан бэ? Энэ нь эрэгтэй, эмэгтэй хүнд байх шинжтэй холбоотой юу?**

---

---

---

---

**Шийдвэрлэсэн арга зам юу байв?**

---

---

---

---

**Энэ явдал хэр олон удаа тохиолдож байгаа вэ?**

---

---

---

---

## Үүнийг хуулийн төсөлд оруулах шаардлагатай юу? Яагаад?

---

---

---

---

### ТАНИЛЦУУЛАХ НЬ

Багууд даалгавраа гүйцэтгэсний дараа намын дарга нар боловсруулсан хуулийн төслөө танилцуулна. Дараа нь бүх оролцогчдоор хэлэлцүүлж, хэрэгжүүлж болохуйц заалтуудыг нэгтгэж батална. Ингэснээр оролцогчид ангидаа дагаж мөрдөх ёстой ЖСХ-ээс сэргийлэх, түүнийг таслан зогсоох хуультай болж байна гэсэн үг юм.

Ангийн хуулийг баталж, дагаж мөрдөж эхэлснээс хойшхи хэрэгжилт, биелэлтийг хичээлийн улирлын эцэст дүгнэнэ. Ингэхийн тулд ангийн хуулийн хэрэгжилтийг хангах, хянах багийг оролцогчдын дундаас сонгоно. Тухайн баг ангийн хууль хэрхэн хэрэгжиж байгаад үнэлэлт дүгнэлт өгөх үүрэгтэйг санаарай.



### ХИЧЭЭЛИЙН ДҮГНЭЛТ

- *Хүчирхийлэлгүй эрүүл, амар амгалан, хүний эрхийг дээдэлсэн нийгмийг бий болгох нь бид бүхнээс эхлэлтэй. Үүний тулд хүн бүрийн оролцоо чухал буюу хүн бүр буруу, болохгүй үйлдэл үзүүлсэн хүнд хэлж ойлгуулах, зэмлэх, буруушаах зэргээр өөрсдийн оролцоог нэмэрлэж болно. Өөрөөр хэлбэл ангийн чинь анд бусдыг ад шоо үзэж, дээрэлхэж байвал тэр дор нь зогсоож, өөрт нь ойлгуулж, сэнхрүүлэх боломж нээлттэй.*
- *Хувь хүн, анги хамт олноороо хүчирхийлэлт харилцаатай дор бүрнээ тэмцэж чадвал орчны өөрчлөлт бий болоход дөхөм үзүүлж, оролцож байна гэсэн үг. Түүнчлэн хүчирхийлэлтэй тэмцэх нийгмийн арга хэмжээ бол нийтээр дагаж мөрдөх хууль, дүрэм журам юм. Тухайн хууль, дүрэм журмыг нийтээр хэрэгжүүлэх үүрэгтэй төдийгүй хүн бүрийн оролцоо чухал.*
- *Чөлөөт цагаараа тараасан материал дээрх хуулиудтай танилцаж, өөрийн болгох хэрэгтэйг сануулаарай.*

**Хичээлийн сэдэв:**

БЭЛГИЙН ЭРҮҮЛ МЭНДЭД ЯМАР  
ҮР ДАГАВАР ҮҮСГЭДЭГ ВЭ?



## МОНДУУЛЫ 5

## ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛИЙН ҮР ДАГАВАР

### ХИЧЭЭЛИЙН ЗОРИЛГО

Хүүхдүүдээ бид түрүүний хичээлээр ЖСХ-ийн улмаас хүний сэтгэл санаанд ямар өөрчлөлт гардаг тухай үзсэн бол энэ удаагийн хичээлээр хүний бэлгийн амьдралд ямар хохирол авч ирдэг тухай үзэх болно.

Ингээд хичээлийн зорилготой танилцацгаая.

*Энэхүү хичээлийн зорилго нь ЖСХ-ийн олон хэлбэрүүдийн нэг болох “бэлгийн хүчирхийлэл”-ийн улмаас үүсэх сөрөг үр дагаврын талаар ойлголт, мэдлэгтэй болохоос гадна хэрхэн яаралтай арга хэмжээ авч болох тухай мэдээлэлтэй болж, түүнийг хэрэгжүүлэх зарим чадварт суралцана. Ингэснээр,*

- *Бэлгийн хүчирхийллийн олон төрлүүдийг мэддэг болно.*
- *Бэлгийн хүчирхийллийн улмаас үүсч болох эрсдэл, үр дагаврын талаар мэдлэгтэй болно.*
- *Бэлгийн хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх, хэрхэн яаралтай хариу арга хэмжээ авахад суралцана.*
- *ЖСХ-ийн улмаас үүсэх сэтгэл санааны хохирлыг танин мэдэх*

### ХИЧЭЭЛИЙН ДАРААЛАЛ

Дараах дасгалуудыг багшийн тусламжтайгаар ажиллах болно.

1. Сэдэлжүүлэлт
2. Мэдээлэлтэй танилцах
3. Хэлэлцүүлэг гэсэн хэсгүүдээс бүтнэ.



**Дасгал 1**

# СЭДЭЛЖҮҮЛЭЛТ

Өмнөх хичээлийн жилүүдэд олж авсан мэдлэгээ богино хугацаанд эргэн санах, бататгахын тулд “Жендэрт суурилсан хүчирхийлэл гэж юу вэ?” гэдэг асуултыг өөрөөсөө асууж, дараах зайд тэмдэглэж үлдээнэ үү! Өөрийн ойлгосноор энгийн үг хэллэг ашиглан хариулах боломжтой.

## ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ ГЭЖ ЮУ ВЭ?

---



---



---



---



---



---



---



**Дасгал 2**

# МЭДЭЭЛЭЛТЭЙ ТАНИЛЦАХ

Багшийн бэлдсэн лекцийг анхааралтай сонсож, ЖСХ-ийн түгээмэл хэлбэрүүдийн талаарх үндсэн ойлголттой болж, чухалд тооцогдох мэдээллийг доорх зайд тэмдэглэж үлдээгээрэй!

<p><b>ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ</b></p>	<p>(сэтгэл санааны, бие махбодийн, бэлгийн, эдийн засгийн)</p>
--------------------------------------	--

<b>БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ/ ХҮЧИН</b>	(ураг төрлийн, гудамж талбайн, болзооны, гэрлэгсдийн)
<b>БЭЛГИЙН ДАРАМТ</b>	(ажлын байрны, боловсрол сургалтын орчинд үйлдэгдэх)
<b>БЭЛГИЙН МӨЛЖЛӨГ</b>	(худалдаалах, хүчээр биеийг нь үнэлүүлэх, хүчээр гэрлүүлэх)





### Дасгал 3

## ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Багш 3 сурагчийг сайн дураараа самбарт гарч ирэхийг хүсэх ба самбарт гарсан 3 сурагч бол багийн ахлагчид юм. Багийн ахлагч болох хүүхдүүд сайн дураараа самбарт гарч ирсний дараа бусад хүүхдүүдээс сонгож өөрийн багаа бүрдүүлнэ. Ингэхдээ нийт сурагчдын тооноос шалтгаалж багтаа хэдэн хүүхэд сонгох боломжтойг хэлнэ.

Багийн ахлагчид өөрийн багаа бүрдүүлсний дараа баг тус бүрт ЖСХ-ийн улмаас бэлгийн эрүүл мэндэд нь хохирол учирсан 1 бодит жишээг сугална. Багууд уг жишээтэй уншиж танилцаад бэлгийн эрүүл мэндэд нь ямар хохирол учирсан болох, цаашдаа ямар арга хэмжээ авах шаардлагатай болохыг багаараа ярилцаж гаргаж ирнэ. Ингэхдээ дараах асуултуудад багууд хариулах ба ярилцаж дууссаны дараа бусад багууддаа танилцуулаарай.

### АСУУЛТУУД

**Хохирогч ямар төрлийн хүчирхийлэлд өртсөн бэ?**

---

---

---

---

---

**Хүчирхийллийн улмаас ямар хор хөнөөл, гэмтэл, үр дагавар үүссэн бэ?**

---

---

---

---

---

**Цаашдаа ямар арга хэмжээ авах вэ?**

---

---

---

---

---



Багууд дараах бодит жишээг сугална.

### **БОДИТ ЖИШЭЭ 1**

*М бол айлын том охин бөгөөд одоо 11-р ангид сурдаг. М хичээл дээрээ фэйсбүүк рүүгээ ороод зургаа постолж, өөр бусад хүмүүсийн зургийг үзэн цагийг өнгөрүүлж байв. Түүний фэйсбүүк рүү нэгэн хүнээс “Hi taniltsah uu” гэсэн мессэж ирэв. М хариу бичихээсээ өмнө түүний зургийг нь үзэхэд өөрийх нь үеийн дажгүй хөвгүүн байв. Тэр Мишээлд таалагдсан учраас түүнтэй танилцаж 2 сар гаруй чатаар харилцлаа. Өдөр өнгөрөх тусам М түүнд улам татагдсаар байв. Нэг өдөр түүнээс “2-уулаа орой кино үзэх үү?” гэсэн мессэж ирэхэд М үнэхээр их баярлаж уулзахаар болов. Орой болж уулзах цаг болж М гэрээсээ яаран гарлаа. Кино театрийн үүдэнд яг цагтаа ирэн танилцсан үеийн хөвгүүнээ харахыг тэсэн ядан хүлээж байлаа. Товлосон цагаас нэлээн өнгөрсөн тул М түүн рүү залгах гэтэл утасны дугаарыг нь асуугаагүй байжээ. Холбоо барьж чадахгүй байсан тул явах гэтэл нэг хүн “уучлаарай хоцорчихлоо” гэсээр ирсэн нь өөрөөс нь нэлээд ах хүн байв. Төсөөлж байснаас нь өөр хүн байсан тул М явах гэтэл нөгөө хүн худлаа хэлсэндээ санаа зовж байна тийм учраас хүргээд өгье хэмээн машин руугаа заав. Гэвч тэрээр М-ийг гэрт нь хүргэж өгөлгүйгээр өөр тийш нь авч очоод, хүчирхийлсэн байна. Энэ явдлаас хойш хэд хоногийн дараа Мишээл өөрийгөө БЗДХ авсан гэдгээ мэдсэн юм.*

### **БОДИТ ЖИШЭЭ 2**

*Өсвөр үеийнхэн болоод том хүмүүс бэлгийн хүчирхийлэлд зөвхөн охидууд л өртдөг гэсэн ташаа ойлголттой байдаг. Б ч гэсэн найзад нь тохиолдсон зүйлээс өмнө тийм л бодолтой байлаа. Гэвч Б-ийн найз Тулгаа 10-р ангиа төгсөөд үл бүтэх хүмүүстэй нийлдэг болж, Б-тэй ч ховорхон уулздаг болжээ. Б найзыгаа тэдгээр хүмүүсээс холдуулах гэж маш их хичээсэн ч огт болохгүй байв. Тулгаагийн найзлах болсон хүмүүс нь өмнө нь гэмт хэрэг хийж, ял шийтгэл хүлээж байсан гэдгийг Б сүүлд олж мэдсэн юм. Тэр хүмүүстэй найзлах болсноор Т-ийн зан ааш эрс өөрчлөгдөж, хичээлээ ч их таслах болов. Сурагчдын амралт болж Б гэртээ зурагт үзээд хэвтэж байв. Нэлээн орой болж унтах гэтэл найз Т-ээс нь дуудлага иржээ. Утсаа автал Т “намайг авраач” гэж хэлээд байгаа газраа зааж өгөв. Б аавдаа хэлж яаран Т-ийн байгаа газар очиж түүнийг эмнэлэгт хүргэж өгчээ. Эмч түүнийг “бэлгийн хүчирхийлэлд өртөж, шулуун гэдэс нь маш их гэмтсэн тул яаралтай мэс засалд орох шаардлагатай байна” гэж хэлжээ.*



### БОДИТ ЖИШЭЭ 3

Н 10-р ангид байхдаа ангийнхаа хөвгүүнтэй үерхэж эхэлсэн бөгөөд сургууль төгссөн жилийнхээ зун нь тэр 2 хүүхэдтэй болж, нэг гэрт хамт амьдрах болжээ. Намар болж нөхөр нь хүссэн их сургуульдаа элсэн суралцаж, харин хүүхэд нь дөнгөж 2 сартай байсан учраас Н их сургуульд орохоо хойшлуулж, хүүхдээ 2 нас хүртэл нь өөрөө асрахаас өөр аргагүй болов. Эдийн засагч болохыг маш их хүсдэг байсан учраас хүүхдээ цэцэрлэгт оруулчихаад л хүссэн сургуульдаа орж, хүссэн мэргэжлээ эзэмшинэ гэж төлөвлөдөг байлаа. Өдөр хоног өнгөрөх тусам Н-ийн нөхрийн ааш араншин өөрчлөгдөж эхлэв. Эхнэр хүүхэддээ тавих анхаарал нь ч багасч, заримдаа ангийнхаа хүүхдүүдтэй хамт шоудана, зугаалгаар явна гээд гэртээ хонохгүй байх, согтуу ирэх тоо нь олширч эхлэв. Н-ийг шаардлага тавих төдийд уурлаж, элдвээр доромжилж, заримдаа бүр гар ч хүрдэг болов.

Н-ийн хүсэн хүлээсэн 2 жил өнгөрч, хүүхэд нь ч цэцэрлэгт орох насанд хүрлээ. Хүүхдээ цэцэрлэгт өгөөд их сургуульд орно гэдгээ нөхөртөө хэлтэл маш их уурлаж, “хүүхэд цэцэрлэгт өгч зовоох гэлээ, хүүхдээ өөрөө харж чадахгүй арчаагүй, чи заавал сургуульд орж яах гэсийн, би та 2-ыг тэжээж чадна, нөхрөө халамжлах, хүүхдээ харах бол эмэгтэй хүний үүрэг” гэх мэтээр дайрч доромжилж, Н-ийн шийдвэрийг хүлээж авахыг огтхон ч хүссэнгүй. Нөхөр нь уурандаа гарч яваад найзуудтайгаа хамт архидаж байгаад шөнө дунд согтуу ирсэн ба Н-ийг хүсэхгүй байхад нь хүчээр бэлгийн харьцаанд оржээ. Хэдэн долоо хоногийн дараа Н дахиад жирэмсэн болсон гэдгээ мэдэв.

## ХИЧЭЭЛИЙН ДҮГНЭЛТ

Энэхүү сэдэвт хичээлийн хүрээнд дараах дүгнэлтийг хийж байна.

- *Олон төрлийн ЖСХ-ийн улмаас бие махбодь, сэтгэл санаа, бэлгийн эрүүл мэндэд хор хохирол учирдаг.*
- *ЖСХ-ийн улмаас бэлгийн эрүүл мэндийн хувьд ноцтой хохирох, нөхөн үржихүйн эрхтэн тогтолцоо гэмтэх, хүсээгүй жирэмслэх, БЗДХ-т өртөх эрсдэл өндөр байдаг.*
- *ЖСХ-ийн үр дагавар нь дан ганцаараа илрэхгүй, ихэнх тохиолдолд давхардсан байдаг. Тухайлбал, ЖСХ-ийн олон төрлүүдийн нэг болох бэлгийн хүчирхийллийн улмаас бие махбодид ноцтой гэмтэл учирч, сэтгэл санааны хүнд цочролд орохоос гадна дээрх бэлгийн эрүүл мэндийн хувьд хохирох өндөр эрсдэлтэй. Харин бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогч бага насандаа жирэмслэх, БЗДХ, ДОХ авах эрсдэл өндөр болох, олон хамтрагчидтай болох, бэлгийн мөлжлөгт автах зэрэг олон сөрөг үр дагавартай.*
- *ЖСХ-ийн улмаас бэлгийн эрүүл мэндийн хувьд хохирсон тохиодолд яаралтай арга хэмжээ авах шаардлагатай. Иймд нөхөн үржихүйн эрүүл мэнд, бэлгийн эрүүл мэндийн боловсролоо нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай юм.*

**Хичээлийн сэдэв:**

ЖЕНДЭРТ СУУРИЛСАН  
ХҮЧИРХИЙЛЛИЙН  
ТОХИОЛДЛЫГ ХЭРХЭН  
МЭДЭЭЛЭХ ВЭ?



## МОНДУУЛЫ 6

### ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛД ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ

## ХИЧЭЭЛИЙН ЗОРИЛГО

Хэн нэгэн хүчирхийлэлд өртөж байгааг мэдсэн, эсвэл өртөж байж болзошгүй гэж таамаглаж байгаа бол түүнд тусламж үзүүлэх ямар нэг алхам зайлшгүй хийх шаардлагатай. Харин хэрхэн тусалж болох талаар суралцахаас өмнө хичээлийнхээ зорилготой танилцаарай!

*“ЖСХ-ийн тохиолдлыг хэрхэн мэдээлэх вэ?” сэдэвт энэ удаагийн хичээлийн гол зорилго нь жендэрт суурилсан хүчирхийллийн мөн чанарыг ойлгож, улмаар ЖСХ-ийн тохиолдлыг хэнд, хэрхэн мэдээлж, хэнээс тусламж эрэх боломжтой тухай ойлголт, мэдлэгтэй болох явдал юм.*

## ХИЧЭЭЛИЙН ДАРААЛАЛ

ЖСХ-ийн тохиолдлыг хэрхэн мэдээлэх арга зүйд дараах дасгалуудыг ажилласнаар суралцах болно.

1. Сэдэлжүүлэлт
2. Дүрийн тоглолт
3. Эрэлхийлэл /гэрийн даалгавар/



### Дасгал 1

## СЭДЭЛЖҮҮЛЭЛТ

Энэ сэдвийн хүрээнд өмнөх жилүүдэд үзсэн хичээлүүдээ эргэн санаарай!

- Эхний жилд үзсэн “Би хэнд итгэж болох вэ?” сэдэвт хичээлийн хүрээнд хамгийн ихээр итгэл хүлээлгэдэг насанд хүрсэн хүмүүсээ тодорхойлж, тэднээс 3 хүнийг сонгож байсан.
- Дараагийн жилд “Би найздаа тусалж чадах уу?” хичээлийн хүрээнд хамгийн сайн найзаасаа захидал хүлээж аваад, түүнд ямар алхам хийж болох талаар зөвлөсөн хариу захидал илгээж байсан. Улмаар ЖСХ-д хэн нэгэнд хэрхэн тусалж болох арга замуудыг эрэлхийлсэн.

Харин хэн хэнд итгэж болох, ЖСХ-д өртсөн найздаа хэрхэн тусалж болох талаар юу сурсанаа эргэн санаж, доорх хүснэгтэд бичнэ үү!

<b>Би хэнд итгэж болох вэ?</b>	
<b>Би найздаа тусалж чадах уу?</b>	

## Дасгал 2

### ДҮРИЙН ТОГЛОЛТЦ

Өмнө нь бид найздаа хариу мессэж илгээж байсан бол харин энэ удаад мессэжний эзэн нь ЧИ өөрөө болох юм. Мессэжний эзний өгүүлж буйгаар чамд ямар нэгэн хүнд бэрхшээлтэй зүйл тулгараад түүнийгээ хэн нэгэнд зориг гаргаж хэлнэ. Харин тэрхүү зориг гарган хэлэх гэж буй хүн чинь “Би хэнд итгэж болох вэ?” сэдэвт хичээлээр тодорхойлсон 3 хүний аль нэг нь байгаа мэтээр төсөөлж ДҮРД ТОГЛОХ юм.

Найзтайгаа хос болоод, нэг нь хүчирхийлэлд өртсөн хүү/охин, нөгөө нь түүний хамгийн их итгэл хүлээлгэсэн “насанд хүрсэн” хүн болж жүжиглэнэ. Дүрд тоглохдоо нэг нь өөрт тохиолдсон хэцүү зүйлийн талаар илэрхийлж буй байдал, нөгөө нь хүлээн авч, ямар нэгэн хариу үйлдэл үзүүлж буй мэтээр жүжиглэнэ гэдгийг анхаараарай! Ингэхдээ ЖСХ-д өртсөн хүү/охины түүхийг өөрсдийнхөөрөө өөрчилж, зохиож болно шүү.

Дараах хүмүүсийг дүрийн тоглолтонд оролцуулах боломжтой.

#### ИТГЭЛ ХҮЛЭЭЛГЭСЭН НАСАНД ХҮРЭГЧИД

- Аав
- Ээж
- Ах
- Эгч
- Хамаатны хүн
- Ангийн багш
- Багш
- Сургуулийн нийгмийн ажилтан
- Сургуулийн эмч
- Цагдаа
- ТББ-ын ажилтан

Энэхүү дасгалыг ажилласнаар хүчирхийлэлд өртсөн гэдгээ хэн нэгэнд хэлэх тийм ч амар байдаггүй, эсрэгээрээ маш хэцүү байдгаас гадна, өөрт тохиолдсон явдлаа хэн нэгэнд хэлэх нь тухайн хүнээс ихээхэн зориг, тэвчээр шаарддаг болохыг ойлгоно.

Мөн түүнчлэн хэрэв хэн нэгэн чамд итгэж, өөрт тохиолдсон хүнд хэцүү зүйлээ зориг гарган хэлэх үед ямар хариу үйлдэл үзүүлэх, хэрхэн туслах, хэнд хамтдаа хандаж болоход суралцах боломжтой болох юм.







## ХИЧЭЭЛИЙН ДҮГНЭЛТ

Ангид ажилласан дасгалууд болон гэрийн даалгаврын үр дүнд дараах хэдэн дүгнэлтийг хийсэн гэдэгт итгэлтэй байна.

- *Өөрт тохиолдсон зүйлээ нуулгүйгээр, заавал мэдээлэх,*
- *Хүчирхийлэлд өртсөн тохиолдолд хамгийн их итгэл хүлээлгэдэг насанд хүрсэн хүндээ мэдээлэх,*
- *Хүнд хэцүү зүйл тохиолдох үед хэрхэн хүнд байдлаас гарах арга замыг урьдчилан эрэлхийлэх нь хожим үүсэх хүндрэлээс хамгаална гэдгийг ойлгох,*
- *Хүчирхийллийн тохиолдлыг заавал зохих хүмүүст, эсхүл байгууллагад мэдээлэх үүрэгтэй гэдгийг ухамсарлах,*

**Хичээлийн сэдэв:**

БИ ӨӨРИЙГӨӨ БОЛОН  
НАЙЗЫГАА ХАМГААЛЖ  
ЧАДАХ УУ?



## МОНДУУЛЫН 7

ЖЕНДЭРТ СУУРИНГАН ХҮЧИРХИЙНЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙНЭХ, ӨӨРИЙГӨӨ ХАМГААЛАХ

### ХИЧЭЭЛИЙН ЗОРИЛГО

ЖСХ-ээс өөрийгөө болон найз нөхдөө, эргэн тойрондоо буй ойр дотны хүмүүсээ хамгаалж чадах мэдлэгтэй, мэдээлэлтэй байна гэдэг маш чухал. “Хүчирхийлэл миний асуудал биш”, “Би хүчирхийлэлд өртөхгүй” хэмээн бодох нь өрөөсгөл юм. Бидэнд болгоомж хэзээд илүүдэхгүй. Ингээд энэ удаагийн хичээлийн зорилго, хүрэх үр дүнтэй танилцаарай!

*“Би өөрийгөө болон найзыгаа хамгаалж чадах уу?” сэдэвт хичээлийн гол зорилго нь өмнөх жилүүдэд үзсэн хичээлүүдээс олж авсан мэдлэгтээ тулгуурлан ЖСХ-ээс өөрийгөө болоод эрсдэлтэй нөхцөлд байгаа хэн нэгнийг хэрхэн хамгаалах арга зүйд суралцах явдал юм.*

*Хичээлийг судалснаар*

- *Бие биенээсээ суралцах замаар ЖСХ-ээс өөрсдийгөө хамгаалах “Аюулгүй алхмын жагсаалт”-тай болно.*
- *“Аюулгүй алхмын жагсаалт”-аа бие даан хэрэгжүүлэх чадварт суралцана.*

### ХИЧЭЭЛИЙН ДАРААЛАЛ

Дараах дарааллын дагуу багшийн зааварчилгааны дор ажиллана.

1. “Аюулгүй алхмын жагсаалт” бүлгийн ажил
2. Хэлэлцүүлэг



### Дасгал 1

## АЮУЛГҮЙ АЛХМЫН ЖАГСААЛТ

Жендэрт Суурилсан Хүчирхийллээс өөрийгөө болон найз нөхдөө, ойр дотны хүмүүсээ хэрхэн хамгаалах тухай багаараа ярилцаж, жагсаалт гаргана. Амьдардаг газар, сурдаг сургууль, гэр бүлийн байдал зэргээ харгалзан үзэж өөрсдийн онцлогт тохирсон “АЮУЛГҮЙ АЛХМЫН ЖАГСААЛТ” бий болгох юм.

Доорх зайд жагсаалтаа бичнэ үү! Бүлгээр ажиллах шаардлагатай тул багийн гишүүн бүрийн оролцоог хангаж, саналыг тусгах ёстойг анхаараарай!

### “АЮУЛГҮЙ АЛХМЫН ЖАГСААЛТ”

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

Өөрсдийн гаргаж ирсэн арга замуудаа бусадтайгаа хуваалцаарай! Ингэснээр ЖСХ-ээс өөрийгөө болоод бусдыг хамгаалах олон талт арга замуудад суралцах боломжтой болно.



## Дасгал 2

### ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Дараах асуултуудын дагуу найзуудтайгаа ярилцаж, харгалзах зайд хариулж бичээрэй!

#### АСУУЛТУУД

**Хамгийн үр дүнтэй аргууд нь аль нь вэ?**

---

---

---

---

**Хамгийн аюулгүй буюу эрсдэлгүй аргууд нь аль нь вэ?**

---

---

---

---

**Үр дүн багатай аргууд нь аль вэ?**

---

---

---

---

**Хамгийн үр дүнтэй хэмээн тооцоолж буй аргуудыг хэрэгжүүлэхэд ямар саад бэрхшээл тулгарч болох вэ?**

---

---

---

---

Өгөгдсөн асуултуудад хариулж дууссаныхаа дараа өөрт төрсөн мэдрэмжээ хэрхэн эерэг аргаар илэрхийлж болох арга замуудын талаар найзуудтайгаа ярилцаарай! Тухайлбал, өөрт тохиолдсон явдлаас үүдэлтэй төрсөн мэдрэмжээ эерэгээр илэрхийлж байсан туршлагаа найзуудтайгаа хуваалцаж болох юм.

Ингэснээр чамаас найзууд чинь, харин чи найзуудаасаа суралцах гайхалтай боломж бий болно.



## ХИЧЭЭЛИЙН ДҮГНЭЛТ

Энэ удаагийн хичээлийн хүрээнд дараах хэдэн дүгнэлтийг хийх боломжтой.

- *Нэн тэргүүнд өөрийн биедээ эзэн байх нь хамгийн чухал. Өөрөөр хэлбэл чиний биед хэн хүрэх, хэн хүрч болохгүйг чи л өөрөө шийдэх эрхтэй. Хэрэв хэн нэгэн хүн чамайг хүсээгүй байхад эмзэг газар чинь хүрвэл хүлцэнгүй дуугуй өнгөрөх бус тухайн үйдлийг таслан зогсоох ямар нэгэн арга хэмжээ авах нь зүйтэй.*
- *Мөн түүнчлэн ҮГҮЙ гэж зоригтойгоор хэлж чаддаг байх нь ч гэсэн ямар нэгэн эрсдэлд оруулахаас сэргийлнэ.*
- *Зарим тохиолдолд зоригтойгоор хашхирч бусдаас тусламж эрж болно. Зарим улс оронд ЖСХ-ээс өөрийгөө хамгаалах аргад хүүхдүүдийг сургаж, чанга хашхирах дадал хийлгэдэг байна.*
- *Мэдээж хэрэг ЖСХ-д өртөхөөс хамгаалж, урьдчилан сэргийлж, шаардлагатай дэмжлэг үзүүлж чадах хүн бол хамгийн их итгэдэг насанд хүрсэн хүн. Тэр хүн нь хэн ч байж болно. Зарим хүүхдүүдийн хувьд эцэг эх нь хамгийн их итгэдэг хүн нь байдаг бол зарим хүүхдүүдийн хувьд багш, нийгмийн ажилтан ч байж болох юм.*



**Хичээлийн сэдэв:**

ЖЕНДЭРТ СУУРИЛСАН  
ХҮЧИРХИЙЛЭЛГҮЙ ОРЧНЫГ  
ХЭРХЭН БИЙ БОЛГОХ ВЭ?





МОНГУУЛЬ

ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛИЙГ ТАСАН ЗОГСОХ

## ХИЧЭЭЛИЙН ЗОРИЛГО

“Өөрчлөлт миний гарт” сэдэвт хичээлийн сүүлийн хичээл болох ЖСХ-гүй орчныг хэрхэн бий болгох талаар судлахад та бүхнийг бэлэн гэдэгт итгэж байна. Түүнчлэн энэхүү хичээлд идэвхитэй оролцсон та бүхэнд талархал илэрхийлье. Ингээд хичээлийн зорилготой танилцаарай.

*Та бүхэнд өөрийн сурч, амьдарч буй орчинд аливаа хүчирхийллийг үл тэвчдэг, үл хүлээн зөвшөөрдөг соёлыг түгээхээс гадна, ЖСХ-гүй орчныг бий болгоход зөвхөн хувь хүн төдийгүй бүлэг хамт олноороо хэрхэн хувь нэмэр оруулж болох тухай сэдэл төрүүлэхэд энэхүү хичээлийн зорилго оршино. Ингэхийн тулд*

- ЖСХ-гүй орчинг бий болгоход сурагчдын оролцох оролцоог бий болгоно.
- ЖСХ-ийг зогсоохын тулд бие биедээ нөлөөлөх нөлөөллийг сайжруулна.

## ХИЧЭЭЛИЙН ДАРААЛАЛ

1. Асуудлыг задлан шинжлэх дасгал
2. Төлөвлөгөө боловсруулах

## Дасгал 1

### АСУУДЛЫГ ШИНЖЛЭХ

Өнөөдрийн хичээлийн эхний үйл ажиллагаа бол та бүхэн сургуулийн орчноо ЖСХ-гүй орчин болгох зорилго бүхий 1 сарын кампанит ажил зохион байгуулах ТӨЛӨВЛӨГӨӨ боловсруулна. Ингэхийн тулд сурагчид бүгд нэг баг болох бөгөөд өөрсдийгөө кампанит ажлын зохион байгуулагчид хэмээн төсөөлнө. Та бүхэн хоорондоо ярилцаад сургуулийн орчинд түгээмэл үйлдэгддэг ЖСХ-ийн нэг хэлбэрийг сонгон авч, түүнийг бууруулах, таслан зогсоохын тулд кампанит ажлынхаа хүрээнд ямар үйл ажиллагаа зохион байгуулах талаар төлөвлөх юм.

Дараах асуултыг ангиараа ярилцан, хариултыг том дэлгэц цаасан дээр буулгаарай.

### АСУУЛТУУД

**Манай сургуулийн орчинд ямар төрлийн ЖСХ үйлдэгддэг вэ? Яагаад ЖСХ мөн бэ?**

---

---

---

---

**Энэ төрлийн ЖСХ гарч байгаа нь ямар шалтгаантай вэ?**

---

---

---

---

**Бид юу хийж болох вэ? Ямар шийдэл/гарц байж болох вэ?**

---

---

---

---

Дээрх асуултуудад хариулсан байдлаа багшдаа танилцуулж, санал солилцоорой. Ингэхэд хүн бүрийн оролцоо жигд байх бөгөөд бие биедээ хүлээцтэй, нээлттэй хандах хэрэгтэйг санаарай. Ингээд дараагийн үйл ажиллагаанд бэлдэцгээе!

## Дасгал 2

# ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ

Өмнөх асуудлыг шинжлэх дасгалын үр дүнд КАМПАНИТ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ боловсруулах даалгаврыг гүйцэтгээрэй! Төлөвлөгөө боловсруулахдаа доорх асуултуудын дагуу ажиллана. Сурагчид боловсруулсан төлөвлөгөөнийхөө дагуу ажиллаж, сургуульдаа ЖСХ-гүй орчныг бий болгох зорилго бүхий кампанит ажлыг зохион байгуулна гэдгийг санаарай.

### КАМПАНИТ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХАД АНХААРАХ АСУУДЛУУД

- **Кампанит ажлын нэр юу вэ?**
- **Хэдий хугацаанд үргэлжлэх вэ?**
- **Яагаад энэхүү кампанит ажлыг зохион байгуулах болсон бэ?**
- **Ямар ямар үйл ажиллагаа зохион байгуулах вэ?**
- **Ямар үр дүн гарах вэ?**
- **Ямар дэмжлэг, туслалцаа хэрэгтэй вэ?**
- **Хэнтэй хамтарч кампанит ажлаа зохион байгуулах вэ?**

Эхний байдлаар боловсруулсан төлөвлөгөөгөө багшдаа танилцуулж, саналыг нь аваарай. Улмаар багшийн хэлсэн санал, зөвлөмжийг төлөвлөгөөгөө илүү нарийн, тодорхой болгоход ашиглаарай. Тодорхой хугацааны дараа төлөвлөгөөг дахин хэлэлцэж, сайжруулсан хувилбараа багштайгаа ярилцаарай. Харин боловсруулсан төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд ямар дэмжлэг хэрэгтэйг багштайгаа мөн зөвлөх хэрэгтэй. Төлөвлөгөөг сайжруулахад хүснэгтэд байгаа бүтцийг ашиглаж болно. Мэдээж та бүхэн ямар ажил төлөвлөхөөс шаардагдах зүйл зэрэг нь өөр өөр байхыг бодолцоорой.

### ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХАД АНХААРАХ ЗҮЙЛС

Төлөвлөөний бүрдэл хэсгүүд	Үйл ажиллагаа	Хариуцах эзэн	Шаардлагатай зүйлс
Кампанит ажлыг зохион байгуулах байр, өрөө тасалгаа	Сургуулийн холбогдох албанаас зөвшөөрөл авах		Хүсэлт илэрхийлсэн
Бичиг хэрэг, ватум цаас	Худалдан авалт, санхүүгийн нөөц		

Төлөвлөгөө боловсруулж ажиллах нь сурагч та бүхний нийгмийн сайн сайхны төлөө сайн дураараа оролцох оролцоо нэмэгдэхээс гадна, аливаа нийгмийн асуудлыг шийдвэрлэх, тэр тусмаа хүчирхийллийг үл хүлээн зөвшөөрөх, үл тэвчих соёлыг түгээх ажил хувь хүнээс өөрсдөөс нь эхэлдэг болохыг ойлгож таних ач холбогдолтой юм.



## ХИЧЭЭЛИЙН ДҮГНЭЛТ


Аливаа хүчирхийллийг бууруулах, таслан зогсоохын тулд тухайн орны Засгийн Газар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэхээс гадна, аливаа байгууллага, бүлгүүд ч идэвхи санаачлагатай оролцох хэрэгтэй.


Түүнчлэн хувь хүн бүр ЖСХ-ийг үйлдэхгүй байх, үйлдэж буй хүмүүст эерэгээр нөлөөлөх, өөрийн ажиллаж, амьдарч, сурч боловсорч буй орчноо хүчирхийлэлгүй, ялгаварлалгүй болгоход өөрийн хувь нэмрээ оруулах боломжтой юм.

ЖСХ-ийг хууль, дүрэм, журмаар зохицуулахаас гадна хувь хүн бүрийн идэвхи, санаачлага, оролцооны дүнд хүчирхийллийг бууруулах, таслан зогсоох боломжтой.


Оролцоо гэдэг нь өөрөө хүчирхийлэл үйлдэхгүй байх, бусдад нөлөөлөх, хүчирхийлэлд өртсөн хүмүүст туслах, найз нөхөд, өөрийн хүрээллийн хүмүүстээ эерэгээр нөлөөлж, хүчирхийлэлт бус харилцааны соёлыг түгээх явдал хэмээн ойлгогдоно.

Хүмүүс хоорондын харилцааны асуудал бүр хүчирхийлэл болохгүй гэдгийг сурагчдад сайн ойлгуулах хэрэгтэй. Тухайлбал, хөвгүүдийн гэнэтийн бүлэг зодооныг хүчирхийлэл гэж хэлэхэд хэцүү. Учир нь энэ (1) санаатай бус, (2) тогтвортой бус буюу нэг удаа л уур уцаар дээд цэгтээ хүрсний үр дүнд зодолдоход хүрсэн болох нь тогтоогдсон бол энэ нь харилцааны зөрчил буюу хүчирхийлэл биш юм. Харин харилцааны зөрчилтэй асуудал олон дахин давтагдаж, шийдэл олоогүйгээс улам даамжирч хэнийг хохироох нь тодорхой, яаж хохироох арга хэрэгсэл, арга мэх тодорхой болсон тохиолдолд хүчирхийлэл хэмээн тодорхойлно. Жишээ нь ангид орж ирэхээс өмнө бүлгээрээ ярилцан шоолохоор хуйвалдсан бол, бие засах газраас гарч ирэхэд нь отоож замыг нь хааж зогсоод гутаан доромжилсон бол үүнийг хүчирхийлэл хэмээн үзнэ.








 **Хаяг:**  
Улаанбаатар хот, Сүхбаатар  
дүүрэг, 6-р хороо, Бага тойруу,  
48-р байр, 305 тоот

 **Утас:** 77119991

 **Цахим шуудан:**  
[mones@mongol.net](mailto:mones@mongol.net),  
[info@mones.org.mn](mailto:info@mones.org.mn),  
[admin@mones.org.mn](mailto:admin@mones.org.mn)

 **Нүүр хуудас:**  
[Mongolian Women's Fund](http://Mongolian Women's Fund)

